



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/100

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 11 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ГАОНӨГ/202212005 дугаар бүхий Баянтоорой тосгонд Говийн мод, сөөг ховор ургамлын үржүүлгийн бааз байгуулах ажлыг "Ихэр марал" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Н.Доной)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Н.Доной)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумьяабазар)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  ДАЛТАНЗАГАС



C:/My documents/-3A-4 doc

000000351